

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 20/4

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг үргэлжлүүлэх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, Ковид-19 вирусн тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэл, хэрэглээний зээлийн хугацаа сунгах талаарх МБХ-ны өмнөх хурлын шийдвэрийн хэрэгжилт, иргэдийн хэрэглээний зээлийн эргэн төлөлтөд үүсч буй хүндрэлийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци өмнөх төсөөллийн орчимд байгаа хэдий ч, цаашид бензин, шатахууны үнэ МБГ-ын хүлээлтээс давж нэмэгдэх тохиолдолд бараа бүтээгдэхүүний үнэ өсч болзошгүй талаар дурдав. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт 2020 оны 2 дугаар улиралд өмнөх төсөөллөөс буурахаар байгааг онцоллоо. Үүнд эдийн засгийн идэвхжил саарснаар боловсруулах, худалдааны салбарын үйлдвэрлэл, бүтээгдэхүүний цэвэр татварын орлого огцом буурахаар байгаа нь голлон нөлөөлөхөөр байна.

Нийт төсвийн орлого 2020 оны эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар, тэнцвэржүүлсэн орлого 16.3 хувиар тус тус буурчээ. Мөн төсвийн тэнцэл эхний 6 сарын байдлаар 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа бөгөөд гадаад, дотоод өрийн үндсэн төлбөрийг оруулж тооцвол төсвийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ 2.6 их наяд төгрөг боллоо. Оны эцэст төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд дотоод зах зээл дээр Засгийн газрын бонд шинээр арилжаалах шаардлага үүсэхээр байгааг МБГ-аас дурдав.

Санхүүгийн данс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 700 орчим сая ам.доллараар муудлаа. Үүнийг (1) МИК 2019 онд 300 сая ам.долларын бонд босгож байсан суурь үеийн нөлөө, (2) ХХБ 500 сая ам.долларын бондын төлбөр төлсөн зэрэг хүчин зүйлс тайлбарлаж байна. Түүнчлэн, нүүрсний экспорт төдийлөн хурдтай сэргэхгүй байна.

Өрхийн өрийн дарамтыг зохистой түвшинд хадгалах, улмаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй макро

зохистой бодлого, түүний хэрэгжилтийн талаар МБГ-аас товч танилцуулга хийлээ. Тус бодлогын арга хэмжээний нөлөөгөөр хэрэглээний зээлийн өсөлт саарч байгаа бөгөөд өр, орлогын харьцаа, хугацаа буурч, улмаар өрхийн өрийн дарамт багасч байгаа талаар онцлов. Тодруулбал, хэрэглээний зээл 2018 онд 40 орчим хувиар өсч байсан бол, 2020 оны 6 дугаар сарын байдлаар жилийн өсөлт -7.8 хувьд хүрч саарчээ. Гэхдээ хэрэглээний зээлийн үлдэгдэл огцом өсөлттэй байсан 2018 оны түвшинд байгааг дурдав.

Танилцуулгын төгсгөлд МБХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын макро зохистой бодлогын шийдвэрийн үр дүнг танилцуулав. Тус шийдвэрийн хүрээнд 75,742 зээлдэгчийн 662.7 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон бөгөөд зээлийн хугацааг дунджаар 6.4 сараар сунгасан болохыг тодотгов. Түүнчлэн, МБХ-ны шийдвэр хэрэгжиж эхэлсэн эхний сарууд буюу 2020 оны 4, 5 дугаар сард нөхцөл өөрчилсөн хэрэглээний зээлийн тоо өндөр байсан бол 6, 7 дугаар сард буурчээ. Тодруулбал, 2020 оны 4, 5 дугаар сард банкууд 7 хоногт дунджаар 9000 орчим зээлийн нөхцөл өөрчилж байсан бол 6 сард 3307 зээл, 7 дугаар сард 1807 зээлийн нөхцөлийг өөрчилжээ. Эдгээр зээлүүдийн 63 хувь нь 6 хүртэл сараар үлдэгдэл хугацааг сунгажээ. Нөхцөл өөрчилсөн зээлүүдийн жигнэсэн дундаж хугацаа болон ӨОХ хугацааны туршид буурч байгааг тодотгов. Тухайлбал, банкууд 4 сараас 6 сар хүртэл өндөр өр, орлогын харьцаа (ӨОХ), урт хугацаатай хэрэглээний зээлүүдийн нөхцөлийг өөрчлөх нь давамгайлж байсан бол 7 дугаар сард харьцангуй богино хугацаатай, бага ӨОХ-тай хэрэглээний зээлүүдийн нөхцөлийг өөрчилжээ.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хэрэглээний зээлийн эргэн төлөлтөнд хүндрэл учирч байгаа хэдий ч хугацаа хэтэрсэн хэрэглээний зээлийн үлдэгдэл өсөөгүй болохыг тодотгов. Гэвч (1) дэлхий дахинд цар тахлын тархалт эрчимжиж, хэзээ намдах нь тодорхойгүй байгаа, (2) цар тахлын нөлөөнд өртсөн хэрэглээний зээлүүдийн 15-16 орчим хувьд нь бүтцийн өөрчлөлт хийгээгүй байгаа, (3) Монгол Улсын Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй багц арга хэмжээ хэсэгчилсэн байдлаар 2020 оныг дуустал хэрэгжихээр байгаа зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж МБХ-ны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлын макро зохистой бодлогын шийдвэрийн хэрэгжих хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах саналыг МБГ-аас гаргав. Үүнээс гадна өмнөх шийдвэрийн хүрээнд 12 сараас богино хугацаагаар хэрэглээний зээлийн хугацааг сунгасан зээлдэгчдэд 12 сарыг гүйцээх байдлаар дахин 1 удаа сунгах боломжийг олгох саналыг мөн оруулав.

Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг, санхүүгийн зах зээлд үүсч буй тодорхой бус байдлыг харгалзан үзээд өрхийн санхүүгийн дарамтыг бууруулах, санхүүгийн тогвортой байдлыг дэмжих зорилгоор МБХ-ны гишүүд хэрэглээний зээлийн бүтцэд өөрчлөлт оруулж, хугацааг сунгах арга хэмжээг үргэлжлүүлэх саналыг дэмжиж, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцүүлэв.

МБХ-ны зарим гишүүд цар тахлын нөлөөнд өртөөгүй боловч, нөхцөл өөрчилж байгаа зээлийн талаар судлах, энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг нягтлах, үндсэн зорилтын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг шалгах шаардлагатай байгаа талаар санал гаргав. Өрхийн хэрэглээг дэмжих зорилгоор Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй багц арга хэмжээ, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах арга хэмжээнүүд нь иргэдийн гар дээр үлдэх орлогыг нэмэгдүүлж байгаа талаар дурдлаа. Өрхийн хэрэглээ нь эдийн засгийн 60 орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 2020 оны 1 дүгээр улиралд эдийн засаг 10 гаруй хувиар буурсан ч, Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр дүнд өрхийн хэрэглээ өсөлттэй гарсныг онцлов. Өөр нэг гишүүний хувьд энэхүү арга хэмжээ нь макро эдийн засагт нөлөө үзүүлэхээс гадна санхүүгийн тогтвортой байдал, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эерэг нөлөө үзүүлж байгаа талаар тодотгов.

Мөн төсвийн алдагдал нэмэгдэж, өрхийн хэрэглээг дэмжих боломж хязгаарлагдмал үед ӨОХ-ны хязгаарлалтыг сулруулах боломж байгаа эсэх талаар хэлэлцэв. Хэдийгээр ӨОХ-г нэмэгдүүлснээр хэрэглээний зээл авах боломж нэмэгдэж, өрхийн хэрэглээг дэмжих боломжтой хэдий ч гадаад худалдааны тэнцэлд дарамт учруулж болзошгүй талаар онцлов. Дотоод эдийн засагт хадгаламж, хөрөнгө оруулалтын зөрүү өндөр хэвээр хадгалагдаж байгаа энэ үед дотоод эрэлтийг дэмжих бодлогыг баримтлах нь гадаад валютын нөөцөд дарамт учруулж болзошгүй юм. Үүнээс гадна иргэдийн гар дээр үлдэж буй орлого нь амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр үлдэх шаардлагатай тул ӨОХ-ны хязгаарлалтыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байгааг дурдлаа. Мөн МБХ-ны 4 дүгээр сарын 13-ны хурлын шийдвэрийн хүрээнд өрхийн түвшинд ӨОХ-г тооцдог болсон, хэрэглээний зээлийн хугацааг сунгаж, зээлийн сарын төлбөрийг бууруулах боломжийг олгосон зэрэг шийдвэрүүд нь иргэдийн гарт үлдэх орлогыг нэмэгдүүлсэн талаар тодотгов.

Хэлэлцүүлгийн төгсгөлд эдийн засгийн нөхцөл байдал сайжирсны дараа ӨОХ-ны зохицуулалтыг дахин харах, ӨОХ-ны хувьд коридор үүсгэх боломжтой эсэх, энэ удаагийн хурлаар авч хэлэлцэж буй асуудалтай төстэй богино

хугацаанд шийдвэр гаргах асуудлуудыг Монголбанкны Ерөнхийлөгчийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэх талаар судлах шаардлагатай гэж МБХ-ны гишүүд санал нэгдэв.

Ийнхүү Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанд нийт 5 гишүүн оролцож, бодлогын саналыг МБХ-ны гишүүд 100 хувь дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засгийн хүндрэлтэй нөхцлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэр гаргалаа.